

БИЙ БИЛГЭЭГ ӨВЛҮҮЛЭН УЛАМЖЛУУЛАХ, СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ "УГСААТАН БИЙ" СУРГАЛТЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд Хамтран ажиллах гэрээний 2.1.6, 2.1.8 дахь заалт, дөрөвдүгээр хавсралтын 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн соёлын биет бус өв, ардын бий биелгээний арга барил, биелэх онцлог, зан үйлийн боловсрол олгох, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, танин мэдүүлэх, орон нутагт бий биелгээг хөгжүүлж түгээн дэлгэрүүлэх зорилгоор "УГСААТАН БИЙ" шавь сургалтыг зохион байгуулж сургагч багш бэлтгэнэ.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Сургалтыг "Монголын язгуур урлагийг өвлөн уламжлагчдын нэгдсэн холбоо" НҮТББ-ын тэргүүн, Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн шилдэг уламжлагч, Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч МУУГЗ Гэндэнгийн Баяртай багш удирдан явуулна.
- 2.2 Сургалтад төрийн болон төрийн бус байгууллага, багш, ажилчид, иргэдийг хамруулна.
- 2.3 Мэргэжлийн болон сохирхогчдын анги тус тус хичээллэнэ.
- 2.4 Бий биелгээний үндсэн ойлголт, техник, хөдөлгөөнийг суралцна.
- 2.5 Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газарт бүртгүүлнэ.
- 2.6 Сургалтын хаалтын тоглолт хийж мэргэжлийн ангийн сургагч багш болон сонирхогчийн ангийн батламж гардуулна.
- 2.7 "УГСААТАН БИЙ" бий биелгээний мэргэжлийн ангид сургагч багшийн сургалтад 15 хоногийн хугацаанд тасралтгүй хичээллэн 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тайлан тоглолтод оролцож Дөрвөд, Баяд, Хотон, Урианхай, Захчин, Торгууд 6 угсаатны бий биелгээг суралцсан, өвлүүлэн уламжлуулах эрх бүхий "СУРГАГЧ БАГШ" сертификат авна.
- 2.8 Сонирхогчийн анги нь 15 хоногийн турш тасралтгүй хичээллэн 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тайлан тоглолтод оролцож суралцсан нэг угсаатны батламжийг гардан авна.

ГУРАВ. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА, БАЙРШИЛ

- 3.1 "УГСААТАН БИЙ" сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл 15 хичээллэнэ.
- 3.2 Дархан-Уул аймгийн Дархан сум, хуучин Дархан Орос клубын байранд өдөр бүр мэргэжлийн анги 10:00-12:00, сонирхогчийн анги 14:00-16:00 цагуудад хичээллэнэ.
- 3.3 Хаалтын тоглолтыг 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Залуучууд театрт зохион байгуулна.

ДӨРӨВ. ҮР ДҮН

- 4.1 Дархан-Уул аймагт бий биелгээний сургагч багштай болсноор соёлын биет бус өв, ардын бий биелгээний арга барил, биелэх онцлог, зан үйлийн боловсрол олгох, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, танин мэдүүлэх, орон нутагт бий биелгээг хөгжүүлж түгээн дэлгэрүүлэх боломжтой юм.